



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2025/002-НА-СТА-ЗГТС**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2025 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396                      Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193                      Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Аудитор: Б.Ариунзул Утас: 89133344                      Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.Хараат бусад аудиторын дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

᠒᠐᠒5.03.᠒5 № 3᠒᠒  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Олон жилийн турш санхүүгийн тайланд илэрхийлэгдэж буй 1,402.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн бодит байдлыг алдагдуулж, байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн үнэн зөв байдлыг тодорхойгүй болгож байна. Иймд уг үлдэгдлийг бууруулах, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Аудитын гол асуудал**

Нийгмийн даатгалын сангийн нийт авлага 2,375.2 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 16 хувиар өссөн нь Эрүүл мэндийн байгууллага болон уул уурхайн компаниудын шимтгэлийн төлбөрийг хугацаандаа төлөөгүйтэй холбоотой бөгөөд энэ нь сангийн төлбөрийн чадварт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

### **Бусад асуудал**

Тайлант онд 57 аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн даатгалд шинээр хамрагдаж, албан журмын даатгалд 12,049, сайн дурын даатгалд 4,580 даатгуулагч бүртгэгдсэнээр нийт даатгуулагчийн тоо 16,629 болж, өмнөх оноос 1,561 даатгуулагчаар буюу 9.3 хувиар өссөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,758,609,690.71</b>	<b>8,504,438,160.42</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>5,754,524,034.46</b>	<b>6,031,343,750.20</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>5,754,524,034.46</b>	<b>6,031,343,750.20</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>5,754,524,034.46</b>	<b>6,031,343,750.20</b>
31211	Төрийн сангийн харилцах	2,789,280.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	5,751,734,754.46	6,031,343,750.20
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,004,085,656.25</b>	<b>2,473,094,410.22</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	574,221,153.20	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,406,284,633.10	1,405,941,780.10
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	937,642,829.28
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>23,579,869.95</b>	<b>129,509,800.84</b>
33510	Байгууллагаас авах авлага	23,579,869.95	108,404,718.52
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	21,105,082.32
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,758,609,690.71</b>	<b>8,504,438,160.42</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>386,329,650.61</b>	<b>1,648,439,587.21</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>386,329,650.61</b>	<b>1,648,439,587.21</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>48,964,871.64</b>	<b>360,701,912.12</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	48,964,871.64	0.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0.00</b>	<b>360,701,912.12</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	84,929,199.92
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	254,843,713.79
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.00	20,928,998.41
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>337,364,778.97</b>	<b>1,287,737,675.09</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	337,364,778.97	1,287,737,675.09
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,372,280,040.10</b>	<b>6,855,998,573.21</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,372,280,040.10</b>	<b>6,855,998,573.21</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>7,372,280,040.10</b>	<b>6,855,998,573.21</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	8,118,165,322.21	7,262,159,771.05
51220	Тайлант үеийн үр дүн	-745,885,282.11	-406,161,197.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,758,609,690.71</b>	<b>8,504,438,160.42</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>112,767,276,541.64</b>	<b>125,893,753,311.26</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>33,999,943,033.26</b>	<b>38,301,776,943.36</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>33,999,943,033.26</b>	<b>38,301,776,943.36</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,440,307,395.43	32,026,025,117.38
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,450,824,955.47	3,364,441,535.13
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,751,095,737.79	1,798,153,977.74
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	458,782,563.86	1,113,156,313.11
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,898,932,380.71	0.00
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>179,172,369.31</b>	<b>91,533,193.28</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>179,172,369.31</b>	<b>91,533,193.28</b>
120002	Хүүгийн орлого	43,192,327.43	45,330,355.76
120003	Торгуулийн орлого	0.00	208,500.00
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>101,329,615.63</b>	<b>0.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,329,615.63	0.00
120009	Бусад орлого	34,650,426.25	45,994,337.52
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>78,588,161,139.07</b>	<b>87,500,443,174.62</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>9,760,327,159.00</b>	<b>20,155,353,853.62</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,760,327,159.00	20,155,353,853.62
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>68,827,833,980.07</b>	<b>67,345,089,321.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,827,833,980.07	67,345,089,321.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>113,513,161,823.75</b>	<b>126,299,914,509.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>113,513,161,823.75</b>	<b>126,299,914,509.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,918,980.00</b>	<b>12,315,360.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,918,980.00</b>	<b>12,315,360.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	6,664,770.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,918,980.00	5,650,590.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>113,508,242,843.75</b>	<b>126,287,599,149.10</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>69,062,388,984.00</b>	<b>88,056,173,559.62</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	69,062,388,984.00	88,056,173,559.62
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,445,853,859.75</b>	<b>38,231,425,589.48</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,445,853,859.75	38,231,425,589.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-745,885,282.11</b>	<b>-406,161,197.84</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-745,885,282.11</b>	<b>-406,161,197.84</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>114,494,055,628.58</b>	<b>133,851,651,264.03</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>33,966,598,394.33</b>	<b>46,405,770,332.72</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>33,966,598,394.33</b>	<b>46,405,770,332.72</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,433,377,291.28	32,465,845,507.61
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,448,885,940.57	3,300,580,049.24
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,745,392,803.58	2,775,052,786.42
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	456,627,088.84	1,119,682,517.96
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,882,315,270.06	6,744,609,471.49
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>168,879,654.18</b>	<b>183,103,210.31</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>168,879,654.18</b>	<b>183,103,210.31</b>
120002	Хүүгийн орлого	36,315,829.93	45,609,279.41
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>132,563,824.25</b>	<b>0.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	132,563,824.25	0.00
120009	Бусад орлого	0.00	137,493,930.90
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>80,358,577,580.07</b>	<b>87,262,777,721.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>11,530,743,600.00</b>	<b>19,917,688,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,530,743,600.00	19,917,688,400.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>68,827,833,980.07</b>	<b>67,345,089,321.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,827,833,980.07	67,345,089,321.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>113,586,819,462.02</b>	<b>133,574,831,548.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>113,586,819,462.02</b>	<b>133,574,831,548.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,918,980.00</b>	<b>107,956,461.26</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,918,980.00</b>	<b>12,315,360.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	6,664,770.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,918,980.00	5,650,590.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>95,641,101.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	95,641,101.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>113,581,900,482.02</b>	<b>133,466,875,087.03</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>69,136,046,622.27</b>	<b>87,830,371,997.04</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	69,047,377,527.42	87,830,371,997.04
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	88,669,094.85	0.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,445,853,859.75</b>	<b>45,636,503,089.99</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,445,853,859.75	45,636,503,089.99

III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>907,236,166.56</b>	<b>276,819,715.74</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>907,236,166.56</b>	<b>276,819,715.74</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,847,287,867.90	5,754,524,034.46
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,754,524,034.46	6,031,343,750.20
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	0.00	28,450,575,856.61

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,121,770,634.88	8,121,770,634.88
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-3,605,312.67	-3,605,312.67
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	8,118,165,322.21	8,118,165,322.21
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-745,885,282.11	-745,885,282.11
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	7,372,280,040.10	7,372,280,040.10
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	7,372,280,040.10	7,372,280,040.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-110,120,269.06	-110,120,269.06
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	7,262,159,771.04	7,262,159,771.04
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-406,161,197.84	-406,161,197.84
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	6,855,998,573.20	6,855,998,573.20

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>93,025,019,700.00</b>	<b>87,842,687,357.04</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>93,025,019,700.00</b>	<b>87,842,687,357.04</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>14,144,000.00</b>	<b>12,315,360.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,144,000.00</b>	<b>12,315,360.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,903,300.00	6,664,770.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,240,700.00	5,650,590.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,010,875,700.00</b>	<b>87,830,371,997.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>93,010,875,700.00</b>	<b>87,830,371,997.04</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	93,010,875,700.00	87,830,371,997.04
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>93,025,019,700.00</b>	<b>59,669,452,551.64</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>19,917,688,400.00</b>	<b>19,917,688,400.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	19,917,688,400.00	19,917,688,400.00
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>73,107,331,300.00</b>	<b>39,751,764,151.64</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	73,107,331,300.00	39,751,764,151.64
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	5,754,524,034.46
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	6,031,343,750.20

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон автомашинтай холбоотой 1 холбоотой зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 51,231.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 51,231.2 мянган төгрөгийн алдааг залруулж, шимтгэлийн авлаатай холбоотой 1 зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Залруулсан алдаа:

- Санхүүгийн мөнгөн гүйлгээний тайланд 51,23.2 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлыг илүү илэрхийлснийг залруулсан.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс даваагүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөх саналтай байна.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Авлагын данстай холбоотой

##### Илрүүлэлт:

Олон жилийн турш санхүүгийн тайланд тусгагдаж ирсэн **1,405,941.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл** нь байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн үнэн зөв байдлыг тодорхойгүй болгож, санхүүгийн тайлангийн бодит байдлыг алдагдуулж байна..

##### Өгсөн зөвлөмж:

**Авлагын үлдэгдлийг** бодит байдлыг нь тодорхойлох, барагдуулалтыг эрчимжүүлэх, найдваргүй авлагыг зохих журмын дагуу зохицуулах, санхүүгийн тайлангийн ил тод байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд зардал илүү илэрхийлсэн	1	51,231.2			1	51,231.2	1	51,231.2						
Дүн	1	51,231.2			1	51,231.2	1	51,231.2						

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

Олон жилийн турш санхүүгийн тайланд илэрхийлэгдэж буй 1,405,941.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлэй байна.	1						1				
Дүн	1						1				

### 6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ЗГТС	1	1	-	-	1	-	-	-
	<b>НИЙТ</b>	1	1	-	-	1	-	-	-